

## “ПРАКТИКАЛ ДААТГАЛ” ХХК-ИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “Залгамж халааны бодлого” /цаашид “Бодлого” гэх/ -ын зорилго нь “Практикал даатгал” ХХК-ийн /цаашид “Компани” гэх/ эрх бүхий албан тушаалтны залгамж халааг төлөвлөх, компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, даатгуулагчдын итгэлийг хүлээх нөхцөлийг хангахад оршино.
- 1.2 Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогыг батлан, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо /цаашид “Хороо” гэх/ нь хэрэгжүүлж ажиллана.
- 1.3 Компанийн эрх бүхий албан тушаалтан гэдэгт дараах албан тушаалтнуудыг ойлгоно. Үүнд:
  - ТУЗ-ийн дарга, гишүүд;
  - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
  - Гүйцэтгэх захирал;
  - Санхүү хөрөнгийн удирдлагын газрын захирал (Ерөнхий нягтлан бодогч)

### ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 Хороо нь дотоод болон гадаад эх үүсвэрээс эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангах тохиромжтой этгээдийг тодорхойлж, нэр дэвшүүлнэ.
- 2.2 Хороо нь нь эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно.
- 2.3 Эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшиж буй этгээд нь нэр дэвших хүсэлт, томилогдсон тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай цаг хугацааг зориулах боломжтой, хүсэл тэмүүлэл бий гэдгээ бичгээр илэрхийлнэ.
- 2.4 Хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвшиж буй этгээдийн хараат бус байдлыг хэрхэн тодорхойлсон, бусад компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг эсэх талаар Хувьцаа эзэмшигчид дэлгэрэнгүй танилцуулна.
- 2.5 Хороо нь ТУЗ-ийн гишүүнээр ажилласан нийт хугацаа, өмнөх бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үнэлгээ зэрэг мэдээлэлд дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан дэвшүүлэх, томилох, эсхүл чөлөөлөх саналыг гарган Хувьцаа эзэмшигчид танилцуулна.
- 2.6 Хороо нь өндөр насны тэтгэвэрт гарах, жирэмсний амралтаа авах гэх мэт таамаглаж болохуйц эрх бүхий албан тушаалтны ажлын байрны хэрэгцээг урьдчилан төлөвлөж, нэр дэвшигчийг тодорхойлж ажиллана.
- 2.7 Компанийн бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны шинэчлэлтэй холбоотойгоор эрх бүхий албан тушаалтны орон тоонд өөрчлөлт орох тохиолдолд Хороо санал дүгнэлт гарган, Хувьцаа эзэмшигчтэй зөвшилцөн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батална.
- 2.8 Хороо нь эрх бүхий албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлж, үнэлж, дүгнэх замаар бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.9 Компанийн Хүний нөөцийн удирдлагын газар болон ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь

Хороонд судалгаа, тайлан, мэдээлэл тайлан хүргүүлэх, хамтарсан төлөвлөгөө гаргах замаар хамтарч ажиллана.

- 2.10 Хүний нөөцийн удирдлагын газар нь Гүйцэтгэх захирлын хамтаар компанийн ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг гаргах бөгөөд албан тушаал дэвшин ажиллах боломжтой, чадварлаг ажилтнуудыг тодорхойлж, ур чадварыг нь хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.11 СЗХ болон бусад эрх бүхий байгууллагаас эрх бүхий албан тушаалтныг тохиромжтой бус этгээд гэж үзсэн мэдэгдэл ирүүлэх тохиолдолд мэдэгдэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, тохиромжтой этгээдийг хангуулах ажлыг ТУЗ нь Гүйцэтгэх захирлын хамт хэрэгжүүлнэ.

## **ГУРАВ. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

### **АРГА ХЭМЖЭЭ**

- 3.1 ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга болон 3 болон түүнээс дээш сарын хугацаанд чөлөө авах, өвчтэй байх тохиолдолд түүнийг орлон ажиллах этгээдийг Хувьцаа эзэмшигч томилно.
- 3.2 Гүйцэтгэх захирал, 3 болон түүнээс дээш сарын хугацаанд чөлөө авах, өвчтэй байх тохиолдолд түүнийг орлон ажиллах этгээдийг Хорооны санал, дүгнэлтэд үндэслэн ТУЗ томилно.
- 3.3 Санхүү хөрөнгийн удирдлагын газрын захирал (Ерөнхий нягтлан бодогч) нь урт хугацаанд чөлөө авах, өвчтэй байх үед орлон ажиллах этгээдийг гүйцэтгэх захирал томилно. Ийнхүү томилсон этгээд нь мэдлэг, туршлагын хувьд хангалтгүй гэж Хороо үзсэн тохиолдолд Гүйцэтгэх захиралтай зөвшилцсөний үндсэн дээр томилгоог өөрчилж болно.
- 3.4 Эрх бүхий албан тушаалтан нас барсан, өөр бусад гэнэтийн шалтгааны улмаас орон тоо нь чөлөөлөгдөх тохиолдолд хороо яаралтай хуралдаж, дүгнэлт боловсруулан ТУЗ-д танилцуулна.

### **ДӨРӨВ. БУСАД**

- 4.1 Энэхүү Бодлого болон холбогдох журмуудын хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллаж, ТУЗ-ийг мэдээллээр хангаж ажиллана.
- 4.2 ТУЗ-өөс энэхүү бодлогын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

## **ТАВ. БОДЛОГЫН ТАЛААР НИЙТЭД**

### **МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ТУХАЙ**

- 5.1 Энэхүү бодлогын талаарх мэдээллийг компанийн жилийн тайланд оруулж, бодлогын баримт бичгийг компанийн цахим хуудсанд байршуулна.

“ПРАКТИКАЛ ДААТГАЛ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2023 ОН